



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/28

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Ховд сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Б.Батнасан	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүдэд:	Б.Далайбаяр	-Эрүүл мэндийн газрын эдийн засагч
	Ц.Соёлмаа	-Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Т.Хундыз	- Иргэний төлөөлөл
Нарийн бичгийн дарга:	Э.Цолмон	-Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Б.Батнасан/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Э.Цолмон /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



02 00179
D:\Tush-A\28-Da